

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/006/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-22
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. Аудитын тайлан	23-26
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	27-31
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	32-33

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.АРИУНЖАРГАЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025-03-25 № ЦЭА-2025/006/НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ЗДТГ нь **827.4** мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл цалинг илүү тооцож, олгосон,
- ИТХ, ЗДТГ нь төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **9,232.8** мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн,
- ИТХ, ЗДТГ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс **35,765.9** мянган төгрөгийн батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- ИТХ нь хурлын төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **375.0** мянган төгрөг илүү зарцуулсан,

- Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад зардлыг **5,000.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол хийсэн,
- Их хаан бугуйвч ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан “2 хүний био жорлон хийж, суурилуулах” 11 дугаартай гэрээний төлбөр **19,550.0** мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн боловч хөрөнгийг хүлээн аваагүй, авлага үүсгэсэн,
- ЗДТГ нь улс төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл, тохижилт үйлчилгээний албан хаагчдын цалинг ТАЦНС-ээр тооцоогүйтэй холбоотойгоор НДШ-ийн 4,455.2 мянган төгрөгийн, ХХОАТ-ын 15,982.8 мянган төгрөг зэрэг нийт **20,538.0** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн боловч бүртгэлд тусгаагүй,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, ЗДНХ-ийн батлагдсан төсвөөс сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн боловч хүлээн аваагүй,
- ЗДТГ нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **70** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Оршин байх” “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын ИТХ-ын “Алтанбулаг сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 151 дүгээр тогтоолоор тайлант онд 958,331.0 мянган төгрөгийн татварын орлого, 81,162.5 мянган төгрөгийн татварын бус орлого, өөрийн орлого 500.0 мянган төгрөг, нийт **1,039,993.5** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **1,139,896.3** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ-Ундром ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 3 жилийн хугацаатай “Алтанбулаг сум дахь тохижилт, үйлчилгээний төслийн хамтран ажиллах гэрээ”-г байгуулан сумын төвийн хогийг дуудлагаар авч хогийн нэгдсэн цэгт хаях, хог хаягдлын хураамжийн орлогыг тогтмолжуулах, хогийн цэгийн ашиглалтыг хариуцаж хамтран ажиллахаар тусгажээ.

Тохижилт үйлчилгээний зардалд ЗДНХ болон ЗДТГ-ын батлагдсан төсвөөс Сэлэнгэ-Ундром ХХК-д 12,836.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Үүнд:

- Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний батлагдсан төсвөөс 5,000.0 мянган төгрөгийн нэгдсэн хогийн цэгийн хог түрэх, зам гаргах ажлын хөлс,

- Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/187 дугаар захирамжаар ЗДНХ-өөс 1,211.0 мянган төгрөгийн дайрга, ЗДТГ-ын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 600.0 мянган төгрөгийн давс,
- ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагааны урсгал засварын зардлаас 726.0 мянган төгрөгийн сэлбэг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас Чөлөөт бүсийн хаалган дээр байрлах хогны төлбөр хураах байрны цахилгааны холбох ажилд 1,699.0 мянган төгрөг, дайрга худалдан авах 3,600.0 мянган төгрөг гэх мэт.

Харин тохижилт үйлчилгээний албан хаагчдыг ЗДТГ-т гэрээгээр ажиллуулан цалин, НДШ-ийн зардалд нийт 77,196.7 мянган төгрөгийг цалингийн болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын батлагдсан төсвөөс санхүүжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Алтанбулаг сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 272 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.5 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	449,557.4	589,925.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	239,304.6	463,124.9
33	АВЛАГА	143,515.6	54,144.0
35	БАРАА МАТЕРИАЛ	66,737.2	72,657.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,237,813.8	6,679,137.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,237,813.8	6,679,137.7
39200	Биет хөрөнгө	2,086,668.0	6,528,048.1
39300	Биет бус хөрөнгө	151,145.8	151,089.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,687,371.2	7,269,063.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	732.3	9,965.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	732.3	9,965.2
41300	Өглөг	732.3	9,965.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,686,638.9	7,259,098.4
51	Засгийн газрын хувь оролцоо	2,686,638.9	7,259,098.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,269,358.1	1,269,358.1
51200	Хуримтлагдсан үр дүн	526,532.7	5,098,992.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	890,748.2	890,748.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,687,371.2	7,269,063.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,621,519.9	7,214,973.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	565,019.1	1,005,151.5
110	Орлогын албан татвар	385,431.0	808,597.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	432,702.6	878,862.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(47,271.7)	(70,264.8)
113	Хөрөнгийн албан татвар	59,312.7	95,698.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	120,275.4	100,856.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	853,610.1	4,878,603.5
120	Нийтлэг татварын бус орлого	853,610.1	4,878,603.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,890.7	1,331,218.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,835,025.5	2,122,819.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,690,951.1	2,122,819.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,671,859.5	2,085,617.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	504,772.2	878,530.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,852.1	108,566.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,236.8	526,864.6
2104	Хангамж, бараа материалын зардал	46,654.7	37,507.1
2105	Нормативт зардал	1,151.2	2,942.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,887.5	38,518.8
2107	Томилолт, зочны зардал	5,525.9	7,221.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	549,593.8	113,629.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	411,185.3	371,836.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,091.6	37,202.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	144,074.4	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	786,494.5	5,092,154.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	516,676.6	519,694.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	269,817.8	4,572,459.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,416,821.1	-	2,416,821.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,416,821.1	-	2,416,821.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	269,817.8	-	269,817.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,686,638.9	-	2,686,638.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,686,638.9	-	2,686,638.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,686,638.9	-	2,686,638.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	4,572,459.5	-	4,572,459.5
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,259,098.4	-	7,259,098.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,965,164.0	2,565,640.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	565,019.1	1,005,151.5
110	Орлогын албан татвар	385,431.0	808,597.5
1100	Хувь хүний орлогын албан татвар	432,702.6	878,862.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(47,271.7)	(70,264.8)
113	Хөрөнгийн албан татвар	59,312.7	95,698.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	120,275.4	100,856.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,391.6	27,617.6
1181	Газрын төлбөр	42,954.0	-
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	50,929.9	73,238.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,254.2	224,116.4
120	Нийтлэг татварын бус орлого	197,254.2	224,116.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,202,890.7	1,336,372.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,316,865.5	1,770,355.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,316,865.5	1,770,355.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,297,773.9	1,733,153.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,120.5	869,201.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,852.1	108,599.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,910.8	526,864.6
2104	Хангамж, бараа материалын зардал	33,469.4	34,992.0
2105	Нормативт зардал	7.3	227.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,584.9	60,102.9
2107	Томилолт, зочны зардал	5,363.9	7,221.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	554,398.4	88,158.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,066.6	37,785.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,091.6	37,202.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	648,298.4	795,285.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	790,163.0	571,464.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	790,163.0	571,464.9
2200	Дотоод эх үүсвэрээр	790,163.0	571,464.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(790,163.0)	(571,464.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(141,864.5)	223,820.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	381,169.2	239,304.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	239,304.6	463,124.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,541,807.5	2,315,895.6	225,911.9	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,848,862.1	1,791,243.2	57,618.9	96.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,811,657.1	1,754,041.2	57,615.9	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	869,474.7	869,201.3	273.4	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,592.3	108,599.7	992.6	99.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	540,410.3	526,864.6	13,545.7	97.5
2104	Хангамж, бараа материалын зардал	37,976.2	32,623.7	5,352.5	85.9
2105	Нормативт зардал	615.3	227.4	387.9	37.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,065.2	57,797.9	6,267.3	90.2
2107	Томилолт, зочны зардал	10,144.3	7,221.7	2,922.6	71.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,472.7	119,062.8	18,409.9	86.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,906.1	32,442.0	9,464.1	77.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,205.0	37,202.0	3.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,205.0	37,202.0	3.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	557,945.4	524,652.5	33,292.9	94.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	135,000.0	-	135,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,541,807.5	2,401,994.1	139,813.4	94.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,327,452.2	2,311,551.0	15,901.2	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	214,355.3	90,443.1	123,912.2	42.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	177,143.5	(177,143.5)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	263,241.9	(263,241.9)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	57.0	51.0	6.0	89.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.0	25.0	3.0	89.3
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.0	25.0	3.0	89.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		28,792.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		28,792.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		20,770.7
2104	Хангамж, бараа материалын зардал		2,368.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,305.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,297.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,022.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,022.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		28,792.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		28,792.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Ицаашид Алтанбулаг сумын ТТЗ гэхл* нь “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 00 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 00 мянган төгрөгийн 00 албан шаардлага, 00 мянган төгрөгийн 00 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дотоод хяналт, шалгалтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналт, шалгалтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Алтанбулаг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,581,692.3 мянган төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	239,304.6	463,124.9	223,820.3
Авлага	143,515.6	54,144.0	(89,371.6)
Бараа материал	66,737.2	72,657.0	5,919.8
Үндсэн хөрөнгө	2,237,813.8	6,679,137.7	4,441,323.9
Нийт хөрөнгө	2,687,371.2	7,269,063.6	4,581,692.3
Өр төлбөр	732.3	9,965.2	9,232.8
Засгийн газрын хувь оролцоо	2,686,638.9	7,259,098.4	4,572,459.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,687,371.2	7,269,063.6	4,581,692.3

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 463,124.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 223,820.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	239,304.6	463,124.9	223,820.3
Төгрөг	239,304.6	463,124.9	223,820.3
Төрийн сангийн харилцах	239,304.6	463,124.9	223,820.3
Дүн	239,304.6	463,124.9	223,820.3

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 199,883.0 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 22,990.7 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 240,124.2 мянган төгрөг ХХС-ийн дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 54,144.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 89,371.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	3,426.1	1,787.2	(1,638.9)
Хувь хүмүүст олгосон зээл	140,089.5	52,356.8	(87,732.7)
Дүн	143,515.6	54,144.0	(89,371.6)

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн 52,356.8 мянган төгрөг,
- Зээлийн хүүгийн 1,787.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тайлагнагдсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 72,657.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,919.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	13,755.7	15,388.8	1,633.1
Аж ахуйн материал	50,871.1	54,840.9	3,969.8
Түлш, шатах тослох материал	-	58.0	58.0
Барилгын засварын материал	774.5	774.5	-
Бусад хангамжийн материал	1,335.9	1,594.9	259.0
Дүн	66,737.2	72,657.0	5,919.8

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 49,680.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авса, 15,697.2 мянган төгрөгийн банз, байгаль хамгаалагчийн хувцсыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 59,458.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 516,652.5 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, бусад хангамжийн материалын дансаар дамжуулан хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлснээс тус тус шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 6,679,137.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,441,323.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,086,668.0	6,528,048.1	4,441,380.1
Барилга, байгууламж, орон сууц	551,393.2	1,771,117.3	1,219,724.2
Хуримтлагдсан элэгдэл	(166,077.5)	(208,369.3)	(42,291.8)

Авто-тээврийн хэрэгсэл	250,590.6	283,486.9	32,896.4
Хуримтлагдсан элэгдэл	(114,686.3)	(103,872.7)	10,813.6
Машин тоног төхөөрөмж(компьютер)	300,264.5	2,414,944.8	2,114,680.3
Хуримтлагдсан элэгдэл	(117,485.7)	(138,956.9)	(21,471.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	86,381.3	96,171.0	9,789.8
Хуримтлагдсан элэгдэл	(40,530.0)	(42,724.1)	(2,194.1)
Зам, гүүрийн байгууламж	2,586,140.2	3,941,017.4	1,354,877.2
Хуримтлагдсан элэгдэл	(1,249,322.1)	(1,484,766.3)	(235,444.3)
Биет бус хөрөнгө	151,145.8	151,089.5	(56.3)
Программ хангамж	1,999.5	1,999.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(1,732.7)	(1,788.9)	(56.3)
Бусад биет бус хөрөнгө	150,879.0	150,879.0	-
Дүн	2,237,813.8	6,679,137.7	4,441,323.9

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн хөрөнгөөр 54,812.4 мянган төгрөгийн зөөврийн сууц, био жорлон, машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан,
- УТХО-ын эх үүсвэрээр санхүүжүүлсэн “Жишиг сум” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн уурын зуухны 999,326.7 мянган төгрөгийн барилга байгууламж, 2,123,213.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 857,816.3 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж зэрэг нийт 3,980,356.8 мянган төгрөг,
- УТХО-ын эх үүсвэрээр санхүүжүүлсэн орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд хэрэгжүүлсэн 192,847.4 мянган төгрөгийн хүлэмж, усалгааны тоног төхөөрөмж, нөөцийн сав,
- Аймгийн Замын сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 60,000.0 мянган төгрөгийн зогсоол, гэрэлтүүлэг, БОАЖГ-аас 5,136.4 мянган төгрөгийн мотоцикл, сумын ОНХС-аас 52,760.0 мянган төгрөгийн Дук автомашин, мотоцикл, 737,060.9 мянган төгрөгийн ШТС-аас Дамбо цэцэрлэг хүртэлх сайжруулсан зам зэргийг комиссын актаар хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ-т бүртгэлтэй 25,000.0 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгосны дагуу тайлант онд борлуулж, данс бүртгэлээс хассан, сумын ИТХ-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор 18,884.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,121.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил зэрэг нийт 51,006.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасан зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 9,965.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 9,232.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	732.3	9,965.2	9,232.8
Дүн	732.3	9,965.2	9,232.8

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэлд дараах өглөг тайлагнагдсан байна. Үүнд:

ОНЕО-ын 573.5 мянган төгрөг, ХХС-ийн 158.8 мянган төгрөгийн өмнөх онуудад үүссэн авлага, тайлант онд үүссэн ИТХ-ын 672.2 мянган төгрөг, ЗДТГ-ын 8,560.6 мянган төгрөг зэрэг нийт 9,965.2 мянган төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 7,259,098.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,572,459.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,269,358.1	1,269,358.1	-
Хуримтлагдсан үр дүн	526,532.7	5,098,992.2	4,572,459.5
Өмнөх үеийн үр дүн	256,714.9	526,532.7	269,817.8
Тайлант үеийн үр дүн	269,817.8	4,572,459.5	4,302,641.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	890,748.2	890,748.2	-
Дүн	2,686,638.9	7,259,098.4	4,572,459.5

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Алтанбулаг сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 151 дүгээр тогтоолоор тайлант онд 958,331.0 мянган төгрөгийн татварын орлого, 81,162.5 мянган төгрөгийн татварын бус орлого, өөрийн орлого 500.0 мянган төгрөг, нийт **1,039,993.5** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **1,139,896.3** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	958,331.0	1,039,720.7	81,389.7	108.5
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	486,713.9	502,271.5	15,557.6	103.2
Үйл ажиллагааны орлого	151,956.6	297,883.6	145,927.0	196.0
Хөрөнгийн орлого	36,459.3	32,963.5	(3,495.8)	-
Хөрөнгө борлуулсны орлого	36,459.3	45,743.6	9,284.3	125.5
ХХОАТ-ын буцаалт	(50,000.0)	(70,264.8)	(20,264.8)	140.5
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	7,300.0	14,050.2	6,750.2	192.5
Бууны албан татвар	800.0	1,095.0	295.0	136.9
Малд ногдуулах албан татвар	50,000.0	80,552.8	30,552.8	161.1
Улсын тэмдэгтийн хураамж	10,000.0	6,159.9	(3,840.1)	61.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10,000.0	1,330.4	(8,669.6)	13.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	20,000.0	20,127.4	127.4	100.6
Газрын төлбөр	-	-	-	-
Дуудлага худалдаа	50,000.0	34,569.2	(15,430.8)	69.1
Ойн нөөц ашигласны төлбөр	138,731.7	67,130.9	(71,600.8)	48.4
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	4,585.0	6,007.5	1,422.5	131.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	-	-	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	5,325.2	100.0	(5,225.2)	1.9
Татварын бус орлого	81,662.5	100,175.6	18,513.1	122.7
Торгуулийн орлого	62,604.6	91,597.6	28,993.0	146.3
Бусад орлого	18,557.9	7,506.5	(11,051.4)	40.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	500.0	1,071.5	571.5	214.3
Нийт орлогын дүн	1,039,993.5	1,139,896.3	99,902.8	109.6

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого 15,557.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 145,927.0 мянган төгрөг, торгуулийн орлого 28,993.0 мянган төгрөг, бусад орлого 23,517.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Тайлант онд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор 502,271.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 15,557.6 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Үйл ажиллагааны орлого:** “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн 1072 хувьцааны 2024 оны ногдол ашгийг иргэдэд тараасантай холбоотойгоор 297,883.6 мянган төгрөгийн орлого төвлөрч, 145,927.0 мянган төгрөгөөр давж биелсэн,
- **Малд ногдуулах албан татвар:** Малчин болон мал бүхий иргэдийн татвар төлөлт нэмэгдсэнээр 80,552.8 мянган төгрөгийн орлого төвлөрч, 30,552.8 мянган төгрөгөөр давж биелсэн,

Тасарсан орлого:

- **Газрын дуудлага худалдаа:** Тайлант онд газрын дуудлага худалдааг 3 удаа зарласан боловч 2 дуудлага худалдаанд оролцогч ирээгүйгээс тус орлого 15,430.8 мянган төгрөгөөр тасарсан,
- **Ойн нөөц ашигласны төлбөр:** Аймгийн ИТХ-аас хэрэглээний мод бэлтгэх хуваарийг батлаагүйгээс арчилгаа, цэвэрлэгээгээр 67,130.9 мянган төгрөгийн орлого төвлөрч, 71,600.8 мянган төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,398,465.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 142 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 928,485.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 457,543.4 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 119 дүгээр тогтоолоор сумын төсвийн орлогыг 798,081.9 мянган төгрөг, өөрийн орлогыг 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 68,855.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 145,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг 2,398,465.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор аймгийн 2024 оны төсвийг тодотгож, аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 85,157.3 мянган төгрөгөөр бууруулж, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 23,546.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

Эх үүсвэрийг **228,499.0** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 193,832.9 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн орлогыг 42,578.7 мянган төгрөгөөр,
- Сумын ОНХС-ийн эх үүсвэрийг 42,578.7 мянган төгрөгөөр,
- Ойн нөөц ашигласны төлбөрийг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Хөрөнгө борлуулсны орлогыг 36,459.3 мянган төгрөгөөр бууруулсан.

Зарлагыг **143,341.7** мянган төгрөгөөр нэмэгдүүлж:

- Сумын ОНХС-ийн зардлыг 23,546.7 мянган төгрөгөөр,
- Сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн халаалтын зардлыг 36,192.7 мянган төгрөгөөр,
- Сумын ЗДТГ-ын зардлыг 71,148.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс цалин, НДШ-ийн зардалд 23,404.6 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 20,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 15,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын бохир соруулах, нохой устгах, ковш түрээсэлж хог түрүүлэх, ЭМГ-аас тавьсан актын төлбөрийг төлөхөөр төлөвлөж 12,743.7 мянган төгрөгөөр,

- Сумын ИТХ-ын зардлыг 12,454.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс цалин, НДШ-д 10,234.0 мянган төгрөг, хуралдааны зардлыг 2,220.0 мянган төгрөгөөр гэх мэт.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр **2,541,807.5** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,848,862.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 557,945.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 135,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 1,846,362.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 145,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-аас 481,090.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 500.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 68,855.3 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сэ. Ал. Иргэдийн төлөөлөгчдийн хурал	192,863.8	190,797.8	2,066.0	98.9
2	Сэ. Ал. Засаг даргын тамгын газар	1,149,685.3	1,110,880.4	38,804.9	96.6
3	Сэ. Ал. Орон нутгийн хөгжлийн сан	549,945.4	516,652.5	33,292.9	93.9
4	Сэ. Ал. Сум хөгжүүлэх сан	145,000.0	872.7	144,127.3	0.6
5	Сэ. Ал. Сургууль	246,947.3	245,147.7	1,799.6	99.3
6	Сэ. Ал. Цэцэрлэг	86,745.9	82,767.6	3,978.3	95.4
7	Сэ. Ал. Дамбо цэцэрлэг	31,923.6	31,916.6	7.0	100.0
8	Сэ. Ал. 3-р цэцэрлэг	22,672.8	21,282.6	1,390.2	93.9
9	Сэ. Ал. Хүн эмнэлэг	72,002.8	71,964.9	37.9	99.9
10	Сэ. Ал. Соёлын төв	44,020.6	43,612.8	407.8	99.1
	Дүн	2,541,807.5	2,315,895.6	225,911.9	91.1

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,847,299.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 1,071.5 мянган төгрөг, ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс 89,371.6 мянган төгрөг, ОНХС-аас 464,252.0 мянган төгрөг нийт **2,401,994.1** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,315,895.6** мянган төгрөг буюу **91.1** хувьтай байгаа нь урсгал зардлыг 57,618.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 33,292.9 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 135,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 1,266.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 13,545.7 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 5,352.5 мянган төгрөг, нормативт зардал 387.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 6,267.3 мянган төгрөг, томилолт, зочны зардал 2,922.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 18,409.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад

зардал 9,464.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 3.0 мянган төгрөг зэрэг нийт 57,618.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 12 төсөл, арга хэмжээнд 557,945.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 10 төсөл, арга хэмжээнд 524,652.5 мянган төгрөг олгож, 33,292.9 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

ХХС-аас 135,000.0 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр зээл олгогдоогүй, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 02/32-01 дугаар төлбөрийн актаар тогтоосон 7 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн 2,741.3 мянган төгрөгийн зээлийн алдангийг төлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сумын ЗДТГ-ийн нэмэлт санхүүжилтийн 100130155408 дугаар дансанд аймгийн ЗДНХ-өөс 117.3 мянган төгрөгийн үзэсгэлэн худалдааны шатахуун, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 842.5 мянган төгрөг, БТСГ-аас 800.0 мянган төгрөгийн бүх нийтийн гүйлтийн арга хэмжээний зардал, өмнөх оны татан төвлөрүүлэлт 5,154.0 мянган төгрөг, банзны үнэ 13,250.0 мянган төгрөг, өвсний үнэ 3,860.0 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн үнэ 595.0 мянган төгрөг, журмын хашааны орлого 309.0 мянган төгрөг зэрэг нийт 28,792.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Хангамж, бараа материалын зардалд 849.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,305.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 3,816.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,800.0 мянган төгрөг, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны улсын ахлах байцаагчийн 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 17/32-01 дугаар актаар тогтоосон 18,000.0 мянган төгрөгийн төлбөрөөс 12,000.0 мянган төгрөгийг барагдуулж, зарцуулаагүй үлдэгдэл 8,022.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС, ОНХО, урсгал зардлын төсвөөс 547,302.1 мянган төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэх 1, харьцуулалтын аргаар гүйцэтгэх 2, гэрээ шууд байгуулах аргаар 5, нийт 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 10. Алтанбулаг сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан:

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Гэрээ шууд байгуулах		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХО	5.0	50,064.0	4.0	12,600.0	1.0	37,464.0		
Сумын ОНХС	2.0	479,943.4			1.0	40,000.0	1.0	439,943.4
Урсгал зардал	1.0	17,294.7	1.0	17,294.7				
Дүн	8.0	547,302.1	5.0	29,894.7	2.0	77,464.0	1.0	439,943.4

Эх сурвалж: tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 03 дүгээр сарын 06-ны өдрийн 01/102 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1,835,025.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,350.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой **4,879.6** мянган төгрөгийн дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. ЗДНХ: Сумын түүх соёлын дурсгалт газар, байгалийн цогцолбор газруудыг видео бичлэг, зураг, хар дүрс, фото зурагт буулган хадгалан үлдэх зорилгоор **4,879.6** мянган төгрөгийг “Монголын баялаг өв соёл” ХХК-тай гэрээ байгуулан шилжүүлсэн боловч хүлээн авсан талаарх холбогдох нотлох баримтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “... аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон

нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	181	178	3
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	182	181	1
3	Сумын Засаг даргын Тамгын газар	182	181	1
	Нийт дүн	545	540	5

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант хугацаанд Алтанбулаг сумын ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 27-29 төрлийн нийт 545 мэдээллээс 540 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Өмнөх аудитаар 32 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 138,731.7 мянган төгрөгөөр төлөвлөсөн атал байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд уг орлогын 85.0 хувь болох 117,921.9 мянган төгрөгийг бус 40,701.9 мянган төгрөгийг төлөвлөж, 77,220.0 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1 дэх “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: ... ойн нөөц ашигласны төлбөрийн орлого - 85 хувь”, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1 дэх “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хууль, тогтоомжид нийцүүлэн үнэн зөв төлөвлөж, байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудас хөтлөлт нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 172 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 35,093.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 668.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 17,650.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 16,775.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	668.1	1	668.1	100
Албан шаардлага	2	17,650.0	2	17,650.0	100
Зөвлөмж	5	16,775.5	3	12,835.6	60
Нийт дүн	8	35,093.6	6	31,153.7	75

Эх сурвалж: Алтанбулаг сумын ТТЗ-ийн 2022, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан

шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **2,973,050.2** мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 2,948,210.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,840.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдааг залруулах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

1. Өмнөх оны устгалыг татаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй илэрхийлсэн нийт 2,948,210.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардлыг 1,465,418.9 мянган төгрөгөөр илүү,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд үйл ажиллагааны мөнгөн орлого, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 1,482,791.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Залруулаагүй алдаа:

- Комиссын актаар хүлээн аваагүй 19,550.0 мянган төгрөгийн 2 хүний био жорлонг үндсэн хөрөнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн,
- “Татварын хэсэгт зөөврийн байр худалдан авах” төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 13,290.0 мянган төгрөгийн зөөврийн сууцыг тайлант онд санхүүжүүлсэн 8,000.0 мянган төгрөгөөр тооцож, хөрөнгийн орлогоор тусгасан.

Өгсөн зөвлөмж: Бүртгэл тайланд зөрүүтэй илэрхийлсэн хөрөнгийг 2025 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд залруулах.

Аудитаар нийт **91,289.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **827.4** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **90,461.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, зөрчлийг арилгах **1** зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт:

1. Тооцооллын алдаанаас болж нийт **827.4** мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг илүү олгосон байна.

- Сумын ИТХ: Нарийн бичгийн дарга Т.Уянгад 351.4 мянган төгрөг, мэргэжилтэн Б.Одмаад 242.0 мянган төгрөг нийт 593.4 мянган төгрөг,
- Сумын ЗДТГ: Сумын Засаг даргаар ажиллаж байсан Н.Отгонцогтод 234.0 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.” 20.2.5 дахь “ ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Төлбөр, тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **9,232.8** мянган төгрөгийн НДШ-ийн өглөг үүсгэсэн байна. Үүнд:

- Сумын ИТХ: **672.2** мянган төгрөг,
- Сумын ЗДТГ: **8,560.6** мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны **өглөг**, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан **35,765.9** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ЗДТГ:

- Багаж, техник, хэрэгслийн зардлаас 142.0 мянган төгрөгийн жааз, бэлгийн уут, хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 137.7 мянган төгрөгийн үйлчлэгчийн хувцас, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 3,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт барагдуулсан, 450.0 мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас 550.0 мянган төгрөгийн интернэтийн төлбөр төлсөн зэрэг нийт **4,279.7** мянган төгрөг,
- Тохижилт үйлчилгээний гэрээт ажилтны цалин хөлсийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн батлагдсан төсвөөс санхүүжүүлж, 23,387.0 мянган төгрөгийн цалин, 3,082.8 мянган төгрөгийн НДШ, 1,234.6 мянган төгрөгийн ХХОАТ зэрэг нийт **27,704.4** мянган төгрөгийн ажил, гүйлгээг гүйцэтгэсэн.

Сумын ИТХ:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 450.0 мянган төгрөгийн Си Ти Эс программын төлбөр, 360.0 мянган төгрөгийн архивын шүүгээ, 708.8 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 500.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн засвар, 282.0 мянган төгрөгийн хуралдааны зардал зэрэг нийт **2,300.8** мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас 261.0 мянган төгрөгийн хөшиг, ахмадын хүндэтгэлийн арга хэмжээнд 1,220.0 мянган төгрөг зэрэг **1,481.0** мянган төгрөг гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТТЗ:

3. Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ЗДТГ-т татварын улсын байцаагчийн компьютер техник, хэрэгслийг шинэчлэхэд зориулан **5,000.0** мянган төгрөгийг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн **төсөв алдагдалтай болох** нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй нөхцөл бий болоогүй байхад байгууллагын хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

4. Их хаан бугуйвч ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан “2 хүний био жорлон хийж, суурилуулах” 11 дугаартай гэрээний төлбөр **19,550.0** мянган төгрөгийг бүрэн шилжүүлж, хөрөнгийн бүртгэлд орлого авсан боловч шаардлага хангаагүй гэх үндэслэлээр буцааж, өнөөг хүртэл хүлээн аваагүй байна.

Өөрөөр хэлбэл хүлээн аваагүй хөрөнгийг хөрөнгийн бүртгэлд орлогоор бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1: Аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.2: авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хөрөнгийг 2025 оны эхний хагас жилд багтаан хүлээн авч, ашиглалтад оруулах албан шаардлага хүргүүлэв.

5. Улс төрийн албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл, тохижилт үйлчилгээний албан хаагчдын цалинг ТАЦНС-ээр тооцоогүйтэй холбоотойгоор НДШ-ийн 4,455.2 мянган төгрөг, ХХОАТ-ын 15,982.8 мянган төгрөг зэрэг нийт **20,538.0** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн боловч бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны **өглөг**, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үүссэн өр төлбөрийг 2025 онд нөхөн тооцох, цаашид өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

6. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа **70** нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Сумын ИТХ:

7. Төлөөлөгчдийн хоолны зардлыг бодит ирцээр бус нийт төлөөлөгчдийн тоогоор тооцож, **375.0** мянган төгрөг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хоолны зардлыг хуралдааны бодит ирцээр тооцон зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сумын ТТЗ	1	2,948,210.2			1	2,948,210.2						
Сумын ЗДТГ	2	24,840.0			2	24,840.0			2	24,840.0	2	24,840.0
Дүн	3	2,973,050.2			3	2,973,050.2	1	2,948,210.2	2	24,840.0	2	24,840.0

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ТТЗ	2	5,000.0			1	5,000.0						
Сумын ИТХ	3	5,422.4	1	593.4	2	4,829.0						
Сумын ЗДТГ	4	80,866.7	1	234.0	3	80,632.7						
Дүн	9	91,289.1	2	827.4	6	90,461.7	1	-	1	-	1	-

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Телбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Сумын ТТЗ	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сумын ТТЗ	1	-					1	
Дүн	1	-					1	
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт								
Сумын ТТЗ	1	4,879.6			1	4,879.6		
Дүн	1	4,879.6			1	4,879.6		
Нийт дүн	3	4,879.6			2	4,879.6	1	